



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 02 сарын 15 өдөр

Дугаар А/67


Сүхбаатар сум

Буцалтгүй тусламж үзүүлэх тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, 66 дугаар зүйлийн 66.1, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 15.4, Нийгмийн халамжийн тухай хуулийн 13.5.1, 13.5.4, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ыг 2.1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сүхбаатар сумын 8 дугаар багийн иргэн Х.Отгонжаргалын эрүүл мэндийн байдал хүнд, өрх толгойлсон нөхцөл байдлыг харгалзан эмчилгээний зардалд 500.000 (таван зуун мянган) төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж үзүүлсүгэй.


2. Буцалтгүй тусламжид шаардагдах зардлыг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (О.Мөнхбаяр)-т зөвшөөрсүгэй.



Н.ЛХАГВАДОРЖ





Сэлэнгэ аймгийн Засаг даргын
2022 оны 02 дугаар сарын 18 ны өдрийн
А/67 дугаар захирамжийн хавсралт



БУЦАЛТГҮЙ ТУСЛАМЖ ОЛГОХ ТӨСӨВ

№	Зардлын нэр	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт дүн
Тусламж				
1	нэг удаагийн буцалтгүй тусламж	1	500.000	500.000
2	НИЙТ			500.000

Төсөв зохиосон:
АЗДТГ-ын НБХ-ийн мэргэжилтэн  Э.Оюун-Эрдэнэ
Хянасан:
АЗДТГ-ын СТСХ-н зарлагын мэргэжилтэн Л  Ж.Хишигдэлгэр

